

БАТЛАВ
ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,
ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗРЫН
ДАРГА

Ц.ГАНХҮҮ

МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГУУДАД ГАЗРЫН МОНИТОРИНГИЙН СИСТЕМЭЭР
ДАМЖУУЛЖ ГАЗРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ, ЧАНАРЫН ЗАХИАЛГАТ ХЯНАН
БАТАЛГААНЫ АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭХ УР ЧАДВАР ЭЗЭМШҮҮЛЭХ СУРГАЛТ
ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН УДИРДАМЖ

2020 оны 07 дугаар
сарын 16-ны өдөр

Улаанбаатар
хот

Зорилго:

Энэхүү сургалтын зорилго нь газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны ажлыг цахим хэлбэрээр гүйцэтгэхэд мэргэжлийн байгууллагын албан хаагчдад “Газрын мониторингийн систем”-ийн хэрэглэгчийн түвшиний ур чадвар эзэмшүүлэхэд оршино.

Хугацаа:

2020 оны 07-08 дугаар сард.

Сургалт хийх газар:

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт сургалт зохион байгуулагчид байрлаж, цахимаар сургалтыг зохион байгуулна.

Сургалт хийх програм хангамж:

“Zoom” цахим сургалт, хурал зохион байгуулах програм хангамжийг ашиглана.

“Zoom” програмд холбогдох дугаар: **9769760021**

“Zoom” програмд нэвтрэх нууц үг: **264596**

Сургалтад оролцогчид:

Барилга, хот байгуулалтын сайдын тушаалаар “Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны мэргэжлийн байгууллагын эрх” авсан хуулийн этгээдийн холбогдох инженер, албан хаагчид энэхүү сургалтад хамрагдана.

Сургалтад оролцогчдын бүртгэлийг monitoring.report@gazar.gov.mn цахим шуудангаар хүлээн авах бөгөөд “Хүснэгт 1”-ийн дагуу бүртгэл хийнэ.

Нэг удаагийн цахим сургалтад 20-25 хуулийн этгээдийн албан хаагчдыг оролцуулах бөгөөд сургалт зохион байгуулах хугацааг тухай бүр Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын цахим хуудас /www.gazar.gov.mn/-аар зарлана.

Хүснэгт 1. Бүртгэлийн хүснэгт

| № | Мэргэжлийн байгууллагын нэр | Сургалтад оролцогчийн | | | |
|-----|-----------------------------|-----------------------|--------------|------|--------------|
| | | Овог, нэр | Албан тушаал | Утас | Цахим шуудан |
| 1 | | | | | |
| 2 | | | | | |
| 3 | | | | | |
| ... | | | | | |
| ... | | | | | |


Сургалтын хөтөлбөр:

| № | АГУУЛГА | Хугацаа |
|------------|---|---------|
| 1 | Системийн үндсэн танилцуулга | 30 мин |
| 2 | Системийн бүтэц, зохион байгуулалт | 15 мин |
| 3 | Үндсэн бүртгэл | 15 мин |
| 4 | Системийн удирдлага | 15 мин |
| 5 | Тохиргоо | 15 мин |
| 6 | Лавлах | 15 мин |
| Завсарлага | | 15 мин |
| 7 | Цахим хэлбэрээр захиалгат хянан баталгаа хийх үйл ажиллагаа | 15 мин |
| 8 | Орон зайн мэдээлэл оруулах | 45 мин |
| Завсарлага | | 15 мин |
| 9 | Захиалгат хянан баталгааны дүгнэлтэд орох мэдээллийг системд оруулах, дүгнэлтийг системээс хэвлэх | 60 мин |
| 10 | Захиалгат хянан баталгааг улсын болон байнгын шинжээчид илгээж, баталгаажуулах | 30 мин |

Сургалтад оролцогчдод сертификат олгох:

Сургалтад хамрагдаж, амжилттай суралцсан оролцогчдод сертификатыг цахимаар олгож, Газрын мониторингийн системийн мэдээллийн санд бүртгэж, цаашид газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны ажлыг цахим хэлбэрээр гүйцэтгэх эрхийг нээж өгнө.

Танилцсан:



Р.Ганхуяг /ЗУХАГ-ын дарга/

Хянасан:



П.Нямдаваа /ССМХ-ийн дарга/

Боловсруулсан:



Б.Дөл /ССМХ-ийн ахлах мэргэжилтэн/